



МОНГОЛ УЛСЫН ГАДААД СЕКТОРЫН ТОЙМ

2018 ОНЫ НЭГ ДҮГЭЭР УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

I. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

Урсгал ба хөрөнгийн данс 2018 оны 1 дүгээр улиралд 348 сая ам.долларын алдагдалтай, санхүүгийн данс 239 сая ам.долларын ашигтай гарснаар нийт төлбөрийн тэнцэл 42 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Статистикийн алдаа ба орхигдуулгын дүн 67 сая ам.доллар байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад урсгал ба хөрөнгийн дансны алдагдал 218 сая ам.доллараар буурсан, санхүүгийн дансны ашиг 119 сая ам.доллараар өссөн үзүүлэлттэй байна.

Гадаад валютын улсын нөөц тайлант улирлын эцсийн байдлаар 2,983 сая ам.доллар буюу сүүлийн 3 сарын дунджаар тооцсон импортын 5.98 сарын хэрэгцээг хангах түвшинд байна.

Барааны худалдаа

Төлбөрийн тэнцлийн аргачлалаар тооцсон барааны худалдааны эргэлт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 25% -иар өсч 2,494 сая ам.долларт хүрсэн бөгөөд барааны худалдааны тэнцэл 248 сая ам.долларт хүрч, сүүлийн 15 улирал дараалан ашигтай гарч байна. Үүнд зэсийн баяжмалын экспорт 82 сая ам.доллараар (22%), мөнгөжөөгүй алтны экспорт 81 ам.доллараар (184%) тус тус өссөн хэдий ч СИФ нөхцөлөөр тооцсон нефтийн импорт 2018 оны 1 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 72 сая ам.доллараар (45%), хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 135 сая ам.доллараар (51%) өссөнөөр худалдааны тэнцэл ашиг өнгөрсөн оны мөн үеэс буурсан байна.

Үйлчилгээний худалдаа

2018 оны 1 дүгээр улиралд үйлчилгээний худалдааны алдагдал өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 9%-иар буюу 31 сая ам.доллараар өсч 365 сая ам.долларт хүрсэн байна. Энэхүү алдагдлын өсөлтөд тээврийн үйлчилгээний дансны алдагдал 18 сая ам.доллараар, аялал жуулчлалын үйлчилгээний алдагдал өмнөх оноос 16 сая ам.доллараар өссөн нь голлон нөлөөлжээ.

Анхдагч орлого

Анхдагч орлогын данс 298 сая ам.долларын алдагдалтай гарч алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 6%-иар буюу 18 сая ам.доллараар өссөн.

Тайлант улиралд гадаад бонд үнэт цаасны хүүгийн төлбөрт 75 сая ам.доллар, ногдол ашигт 45 сая ам.доллар, хөрөнгө оруулагчдын зээлийн хүүгийн төлбөрт 68 сая ам.доллар, бусад зээлийн хүүгийн төлбөрт 38 сая ам.доллар, харилцах, хадгаламжийн дансны хүүгийн төлбөрт нийт 24 сая ам.доллар төлсөн байна.

Хоёрдогч орлого


Хувийн гуйвуулга болон хандив тусламжийн шугамаар 2018 оны 1 дүгээр улиралд манай улс нийт 55 сая ам.доллар буюу өнгөрсөн оны мөн үеэс 15 сая ам.доллараар их орлогыг хүлээн авсан байна. Үүнд:

- Гадаадад ажиллаж, амьдарч буй Монгол иргэдээс хүлээн авсан гуйвуулга өмнөх оны мөн үеэс 45.5%-иар өссөн бол гадаад руу шилжүүлсэн иргэдийн гуйвуулга 67.6%-иар өссөн.
- Гадаад хандив тусламжийн орлого өмнөх оны мөн үеэс 20%-иар өссөн байна.


Дүрслэл 1. Төлбөрийн тэнцэл



Дүрслэл 2. Барааны худалдаа



Дүрслэл 3. Үйлчилгээний худалдаа



Хүснэгт 1. Хувийн гуйвуулга 2018, I улирал (улсаар, мян ам.доллар)

	Хүлээн авсан			Шилжүүлсэн		
	Мөнгөн дүн	Хувийн жин	Өсөлт	Мөнгөн дүн	Хувийн жин	Өсөлт
Солонгос	37,300	60%	▲ 115%	6,739	25%	▼ -74%
Америк	11,415	18%	▲ 51%	3,459	13%	▼ -47%
Хятад	372	1%	▼ -80%	1,129	4%	▼ -68%
Гонг Конг	590	1%	▼ -16%	271	1%	▼ -78%
Англи	2,311	4%	▼ -41%	1,184	4%	▼ -68%
ОХУ	246	0%	▼ -66%	1,478	6%	▲ 42%
Сингапур	381	1%	▼ -26%	339	1%	▼ -63%
Швейцарь	1,124	2%	▲ 5x	92	0%	▲ 100%
Герман	973	2%	▼ -8%	755	3%	▼ -39%
Япон	1,003	2%	▲ 3%	706	3%	▼ -55%
Бусад	6,801	11%	▼ -51%	10,554	40%	▲ 47%
НИЙТ	62,516	100%		26,707	100%	

Гадаадын шууд хөрөнгө оруулалт

2018 оны 1 дүгээр улиралд Монгол улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгалын дүн 626 сая ам.доллар, хөрөнгө оруулалтын буцаалт болон зээлийн эргэн төлөлттэй холбоотой гарах урсгал 110 сая ам.доллар буюу цэвэр дүнгээр 516 сая ам.долларын орох урсгалтай байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгалыг өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулбал 372 сая ам.доллараар өссөн байна. Энэ нь хөрөнгө оруулагчийн зээлийн ашиглалт өссөн болон компаниудын ашигт ажиллаатай холбоотой байв.

Шууд хөрөнгө оруулалтын орох урсгалыг улсаар нь авч үзвэл:

- Канад улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 368 сая ам.доллараар өсч 397 сая ам.доллар,
- Люксембург улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт 25 сая ам.доллараар өсч 39 сая ам.долларт хүрсэн,
- Герман улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт 32 сая ам.доллараар буурч 3 сая ам.доллар,
- Сингапур улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт 35 сая ам.доллараар буурч -1 сая ам.долларын урсгалтай гарсан байна.

Харин эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл 2018 оны 1 дүгээр улиралд уул уурхайн салбарт орж ирсэн хөрөнгө оруулалт өнгөрсөн оны гүйцэтгэлээс өссөн үзүүлэлттэй байна.

Салбаруудын хөрөнгө оруулалтын хэмжээг харьцуулбал,

- Уул уурхайн салбарт орж ирсэн хөрөнгө оруулалт 343 сая ам.доллараар,
- Үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбар 33 сая ам.доллараар,
- Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа 40 сая ам.доллараар тус тус өсч,
- Харин бөөний болон жижиглэнгийн худалдааны салбар 34 сая ам.доллараар,
- Барилгын салбар 19 сая сая ам.доллараар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Багцын хөрөнгө оруулалт

Багцын хөрөнгө оруулалтын данс 2018 оны 1 дүгээр улиралд 178 сая ам.долларын алдагдалтай гарсан ч үлдэгдлийн хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 896 сая ам.доллараар өссөн байна.

Тайлант улирлын голлох ажил гүйлгээг дурдвал:

- Чингис бондын үндсэн болон хүүгийн үлдэгдэл төлбөрт 127 сая ам.долларыг буцаан төлсөн,
- Хуралдай бондын хүүгийн эргэн төлөлтөд 26 сая ам.долларыг төлсөн.
- Банк ,аж ахуйн нэгж бондын хүүгийн төлбөрт 16 сая ам.долларыг төлсөн байна.

Бусад хөрөнгө оруулалт

Энэ дансанд санхүүгийн дээрх дансуудад үл хамаарах бусад хөрөнгө оруулалтууд буюу бусад бүх төрлийн зээл (арилжааны, хөнгөлөлттэй, худалдааны зэрэг), бэлэн мөнгө ба харилцах хадгаламжийн дансны эх үүсвэрийг бүртгэдэг.

Тайлант улиралд бусад хөрөнгө оруулалтын дансны пассив 362 сая ам.долларын ашигтай гарсан бөгөөд үүнийг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулбал тэнцэл 320 сая ам.доллараар өссөн дүнтэй байна. Энэхүү өсөлтөд хадгаламжийн байгууллагуудын зээлийн ашиглалт голлон нөлөөлсөн байна.


Хүснэгт 2. ГШХО, орох урсгал, улсаар (сая ам.доллар)

№	Үзүүлэлт	I улирал		2018.I/17.I	Өөрчлөлт
		Дүн	Хувийн жин	Өөрчлөлт	
1	Австрали	2.9	0%	2.3	▲
2	Америк	17.4	3%	-0.6	▼
3	Англи	4.2	1%	-0.7	▼
4	БНХАУ	35.3	6%	-23.3	▼
5	Герман	3.4	1%	-32.1	▼
6	Голланд	-19.5	-3%	-19.5	▼
7	Гонг-Конг	52.4	8%	27.6	▲
8	Канад	396.5	63%	367.6	▲
9	Люксембург	39.3	6%	24.7	▲
10	ОХУ	5.3	1%	2.9	▲
11	Сингапур	-1.2	0%	-34.8	▼
12	Солонгос (өмнөд)	11.2	2%	8.2	▲
13	Турк	0.1	0%	-0.5	▼
14	Франц	0.2	0%	-2.3	▼
15	Япон	29.9	5%	19.0	▲
16	Бусад	48.6	8%	33.5	▲
	Нийт	626.1	100%	372.1	▲

Хүснэгт 3. ГШХО, орох урсгал, салбараар (сая ам.доллар)

№	Эдийн засгийн салбар	I улирал		2018.I/17.I	Өөрчлөлт
		2017	2018	Өөрчлөлт	
1	Барилга	18.6	0.0	-18.6	▼
2	Боловсрол	0.4	0.2	-0.2	▼
3	Боловсруулах үйлдвэрлэл	3.6	0.5	-3.1	▼
4	Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	60.6	26.9	-33.7	▼
5	Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	0.4	4.1	3.7	▲
6	Мэдээлэл, холбоо	2.9	0.0	-2.9	▼
7	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	1.6	0.9	-0.7	▼
8	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	0.0	39.6	39.6	▲
9	T эвээр ба агуулахын үйл ажиллагаа	2.0	3.6	1.6	▲
10	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	0.0	9.8	9.8	▲
11	Уул уурхай, олборлолт	144.7	487.3	342.6	▲
12	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	11.3	44.1	32.8	▲
13	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	3.3	0.4	-2.9	▼
14	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	0.8	0.2	-0.6	▼
15	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	0.2	7.9	7.7	▲
16	Бусад	3.8	0.8	-3.0	▼
	Нийт	254.0	626.1	372.1	▲

Дүрслэл 4. Багцын хөрөнгө оруулалт (сая ам.доллар)



Дүрслэл 5. Бусад хөрөнгө оруулалт



II. ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ПОЗИЦ

Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц 2018 оны 1 дүгээр улирлын эцэст цэвэр дүнгээр 32,592 сая ам.долларын үлдэгдэлтэй буюу өр төлбөртэй байна.

Монгол Улсын эдийн засгийн харьяатаас гадагш хийсэн хөрөнгө оруулалтын дүн (актив) 5,684 сая ам.доллар байна. Үүний 52%-ийг гадаад валютын албан нөөц, 34%-ийг бусад хөрөнгө оруулалтын актив, 9%-ийг шууд хөрөнгө оруулалт, 5%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Харин Монгол Улсын эдийн засгийн харьяатад гадаадаас оруулсан хөрөнгө оруулалтын дүн (пассив) 38,276 сая ам.долларт хүрчээ. Үүний 48%-ийг гадаадын шууд хөрөнгө оруулалт, 39%-ийг бусад хөрөнгө оруулалт, үлдсэн 13%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Гадаад хөрөнгө оруулалтын богино позиц өмнөх оны мөн үеэс 8%-иар буюу 2,328 сая ам.доллараар өссөн байна. Үүнийг

- Ерөнхий бүтцээр авч үзвэл, гадаад актив 49%-иар буюу 1,865 сая ам.доллараар, гадаад пассив 12%-иар буюу 4,193 сая ам.доллараар тус тус өссөн,
- Данс тус бүрээр авч үзвэл, гадаадын шууд хөрөнгө оруулалтын позиц 1938 сая ам.доллараар, багцын хөрөнгө оруулалтын позиц 901 сая ам.доллараар, бусад хөрөнгө оруулалтын позиц 1363 сая ам.доллараар тус тус буурснаар, харин албан нөөц 1,874 сая ам.доллараар тус тус өссөнөөр тайлбарлагдаж байна.
- Тайлант улирлын позицны өөрчлөлтийг бүтцээр авч үзвэл, төлбөрийн тэнцлийн урсгалаар -559 сая, ханшийн өөрчлөлтөөр -182 сая, бусад өөрчлөлтөөр -145 сая, үнийн өөрчлөлтөөр 49 сая ам.доллараар тус тус өөрчлөгджээ.

Шууд хөрөнгө оруулалт

Монгол Улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын үлдэгдлийн 56%-ийг буюу 10,286.2 сая ам.долларыг хувь нийлүүлэгчийн дүрмийн сан дахь хөрөнгө оруулалт, үлдсэн 44% буюу 8,233.6 сая ам.долларыг толгой компаниасаа авсан зээл (компани хоорондын өглөг, санхүүжилт) эзэлж байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын үлдэгдлийг хөрөнгө оруулагч улсаар нь харуулбал:

- Канад улсаас 4976 сая ам.доллар буюу нийт хөрөнгө оруулалтын 27%,
- БНХАУ-аас 4,679 сая ам.доллар буюу 25%,
- Сингапур улсаас 1,641 сая ам.доллар буюу 9%,
- Люксембург улсаас 1419 сая ам.доллар буюу нийт хөрөнгө оруулалтын үлдэгдлийн 8%-тай тэнцэх хэмжээний хөрөнгө оруулалтуудыг тус тус оруулсан байна.

Багцын хөрөнгө оруулалт

Монгол Улсын багцын хөрөнгө оруулалтын гадаад активын үлдэгдэл 2018 оны 1 дүгээр улирлын эцэст 274 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 2%-иар буурсан бол гадаад пассивын үлдэгдэл 4,759 сая ам.долларт хүрч 23%-иар өссөн үзүүлэлттэй байна.


Актив: Эдийн засгийн харьяатуудын эзэмшиж буй үнэт цаасыг гаргасан улсаар нь авч үзвэл Гонг конг 44%, Сингапур болон АНУ тус тус 12%, Англи 6%, Лексембург 6%-ийг тус тус эзэлж байна.

Пассив: Эдийн засгийн харьяатуудын гаргасан үнэт цаасыг эзэмшигч улсаар нь ангилбал АНУ 16%, Англи 8%, Сингапур 6%, Хонг Конг 4%, Лексембург 4%, бусад улс 4%, харин 51% нь хоёрдогч зах зээл дээр арилжаалагдаж байгаа буюу хөрөнгө оруулагч улсыг тодорхойлох боломжгүй үнэт цаас эзэлж байна.


Хүснэгт 4. Позиц (сая ам.доллар)

Үзүүлэлт	3/31/2017	3/31/2018	Өөрчлөлт	
			дүн	хувь
Гадаад хөрөнгө оруулалтын позиц	-30,265	-32,592	2,328	8%
I. Гадаад актив	3,819	5,684	1,865	49%
1. Шууд хөрөнгө оруулалт	459	501	42	9%
2. Багцын хөрөнгө оруулалт	279	274	-05	-2%
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	01	06	05	953%
4. Бусад хөрөнгө оруулалт	1,971	1,920	-51	-3%
5. Нөөц актив	1,109	2,983	1,874	169%
II. Гадаад пассив	34,083	38,276	4,193	12%
1. Шууд хөрөнгө оруулалт	16,540	18,520	1,980	12%
2. Багцын хөрөнгө оруулалт	3,863	4,759	895	23%
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	00	06	06	3097%
4. Бусад хөрөнгө оруулалт	13,680	14,992	1,312	10%


Дүрслэл 6. Гадаад актив, пассив



Дүрслэл 7. Шууд ХО-ын үлдэгдэл, 2018 оны 1 дүгээр улирал



Дүрслэл 8. Багцын ХО-ын үлдэгдэл, 2018 оны 1 дүгээр улирал



III. ГАДААД ӨРИЙН СТАТИСТИК

Монгол Улсын нийт гадаад өр (хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн хөрөнгө оруулалтаас бусад гадаад өр төлбөр)-ийн үлдэгдэл 2018 оны 1 дүгээр улирлын эцсийн байдлаар 27,913 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлээс 2,896 сая ам.доллараар нэмэгдсэн байна.

Улсын салбар: Засгийн газрын гадаад өр 1,398 сая ам.доллараар нэмэгдэж 7,242 сая ам.долларт, харин Монголбанкны гадаад өр 329 сая ам.доллараар нэмэгдэж 2,137 сая ам.долларт хүрчээ.

Бусад салбар: Банк, бусад секторын болон хөрөнгө оруулагчийн зээлийг бүхэлд нь хувийн хэвшлийн салбарын гадаад өр гэж ойлгох бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 1,173 сая ам.доллараар өсч 16,187 сая ам.долларт хүрээд байна.

Банкны салбар

Банкны салбарын гадаад пассивын үлдэгдэл 2018 оны 1 дүгээр улиралд 2,346 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 4 сая ам.доллараар буурчээ.

Гадаад пассивын 41%-ийг урт хугацаат зээл, 26%-ийг бонд өрийн бичиг, 19%-ийг богино хугацаат зээл, үлдсэн 14%-ийг эдийн засгийн харьяат бусын эзэмшиж буй харилцах, хадгаламжийн дансны өглөг тус тус бүрдүүлж байна.

Банкуудын урт болон богино хугацаат арилжааны зээлийн үлдэгдэл харгалзан 970 сая ам.доллар, 439 сая ам.долларт хүрээд байна.

Банкнаас бусад салбар

Банкнаас бусад салбарын буюу аж ахуйн нэгж, иргэдийн гадаад пассив 2018 оны 1 дүгээр улирлын эцэст 16,187 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 1,173 сая ам.доллараар өссөн дүнтэй байна.

Салбарын нийт зээлийн 51% буюу 8,234 сая ам.долларын эх үүсвэр нь аж ахуйн нэгж, байгууллагуудын гадаадын хөрөнгө оруулагчдаасаа авсан зээл буюу компани хоорондын өглөг бөгөөд үүний дийлэнх нь уул уурхайн салбарт ашиглагдсан байна.

Хөрөнгө оруулагчдаас авсан зээлийн эх үүсвэр нь компанийн эргэлтийн хөрөнгө, мөнгөн урсгалыг дэмжих зорилгоор олгогддог урт хугацаат санхүүжилт бөгөөд ихэнх тохиолдолд хүүгүй, хатуу мөрдөх эргэн төлөлтийн хуваарь байхгүй, харилцан тохиролцсоны үндсэн дээр цаашид дүрмийн санд нэмж тооцогдох боломжтой байдгаараа бусад төрлийн зээлийн санхүүжилтээс ялгаатай байдаг.


Эдийн засгийн харьяат аж ахуйн нэгжүүдийн гадаадаас хүлээн авсан экспортын барааны урьдчилгаа болон төлбөрийг хийгээгүй боловч хүлээн авсан импортын барааны төлбөрийн үлдэгдэл тайлант улирлын эцсийн байдлаар 300 сая ам.доллар болсон байна.

Хүснэгт 5. Нийт гадаад өрийн үлдэгдэл (сая ам.доллар)


Үзүүлэлт	3/31/2017	3/31/2018	өөрчлөлт		* %
			дүн	хувь	
Нийт гадаад өр	25,017	27,913	2,896.01	12%	100%
I. Засгийн газар	5,844	7,242	1,398	24%	26%
II. Төв банк	1,807	2,137	329	18%	8%
III. Банк	2,351	2,346.5	-4	0%	8%
Богино хугацаат	741	768.6	27	4%	3%
Урт хугацаат	1,610	1,578	-32	-2%	6%
IV. Бусад сектор	7,473	7,954	480	6%	28%
Богино хугацаат	487	656	169	35%	2%
Урт хугацаат	6,986	7,297	311	4%	26%
V. Хөрөнгө оруулагчаас авсан зээл	7,541	8,234	693	9%	29%

* Нийт өсөлтөд оруулсан хувь

Дүрслэл 9. Банкны салбарын гадаад зээл



Дүрслэл 10. Банк бус хувийн хэвшлийн гадаад зээл



Мэдээллийн эх сурвалж:

1. Засгийн газар: Сангийн яам, Өрийн удирдлагын хэлтэс
2. Монголбанк: ТТБГазар, ССГазар
3. Банк: Банкуудын тайлан тэнцэл, төлбөрийн тэнцлийн сарын мэдээ, гадаад зээлийн бүртгэл
4. Бусад салбар: ААН-ийн Төлбөрийн тэнцлийн улирлын мэдээ, банкуудын гадаад гүйлгээний тайлан, гадаад зээлийн бүртгэлийн мэдээллийг тус тус ашиглав.

ХАВСРАЛТ 1. МОНГОЛ УЛСЫН ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ХУРААНГУЙ ХҮСНЭГТ (сая ам.доллар)

Үзүүлэлт	I улирал			Өөрчлөлт		Өөрчлөлт	
	2016	2017	2018	Дүн	2017/16	Дүн	2018/17
I. УРСГАЛ ДАНС	-165	-148	-360	17	10%	-212	-143%
Бараа ба үйлчилгээний худалдаа	45	92	-117	46	102%	-208	-227%
Кредит	1,102	1,375	1,560	272	25%	186	14%
Дебет	1,057	1,283	1,677	226	21%	394	31%
1. Бараа	373	425	248	52	14%	-177	-42%
1.1 Экспорт Ф.О.Б (кредит)	992	1,210	1,371	217	22%	161	13%
1.2 Импорт Ф.О.Б (дебит)	619	784	1,123	166	27%	338	43%
2. Үйлчилгээ	-328	-334	-365	-5	-2%	-31	-9%
Кредит	110	165	189	55	50%	24	15%
Дебет	438	498	554	60	14%	56	11%
2.1 Тээвэр	-48	-64	-81	-16	-33%	-18	-28%
Кредит	40	67	77	27	67%	10	15%
Дебит	88	131	158	43	48%	27	21%
2.2 Аялал	-90	-98	-113	-8	-9%	-16	-16%
Кредит	24	37	43	13	52%	6	16%
Дебит	114	134	156	20	18%	22	16%
2.3 Бусад үйлчилгээ	-190	-172	-170	18	9%	2	1%
Кредит	46	61	70	15	33%	9	14%
Дебит	236	234	240	-3	-1%	7	3%
3 Анхдагч орлого	-255	-280	-298	-25	-10%	-18	-6%
Кредит	13	18	21	5	41%	3	19%
Дебет	268	298	319	30	11%	21	7%
3.1 Ажилчдын цалин	-16	-13	-14	2	15%	0	-2%
3.2 Хөрөнгө оруулалтын орлого	-239	-267	-286	-28	-12%	-19	-7%
3.3 Бусад	0	0	2	0		2	
4 Хоёрдогч орлого	44	40	55	-4	-10%	15	36%
Кредит	64	58	85	-6	-9%	27	47%
Дебит	20	18	30	-2	-9%	12	69%
Үүнээс: Хувийн гуйвуулга	5	4	7	-1	-25%	3	80%
II. ХӨРӨНГИЙН ДАНС	14	18	12	4	28%	-7	-36%
1. Үйлдвэрлэхгүй санхүүгийн бус хөрөнгийн өсөлт/бууралт	0	0	0	0		0	
Кредит	0	0	0	0		0	
Дебет	0	0	0	0		0	
2. Хөрөнгийн шилжүүлэг	14	18	12	4	28%	-7	-36%
Кредит	15	19	15	5	31%	-5	-23%
Дебет	1	1	3	1	108%	2	190%
Урсгал болон Хөрөнгийн дансны тэнцэл (зээлдүүлэг + / зээлдэг -)	-151	-130	-348	21	14%	-218	-168%
III. САНХҮҮГИЙН ДАНС	-284	-120	-239	163	58%	-119	-99%
Санхүүгийн дансны тэнцэл (зээлдүүлэг + / зээлдэг -)	-284	-120	-239	163	58%	-119	-99%
1. Шууд хөрөнгө оруулалт	-214	-138	-455	76	35%	-317	-230%
1.1 Актив	3	4	10	1	22%	7	194%
1.1.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	3	4	10	1	22%	7	194%
1.1.2 Өрийн хэрэгсэл	0	0	0	0	#DIV/0!	0	
1.2 Пассив	216	141	465	-75	-35%	324	229%
1.2.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	26	81	228	55	207%	147	182%
1.2.2 Өрийн хэрэгсэл	190	61	237	-130	-68%	176	291%
2. Багцын хөрөнгө оруулалт	-5	54	150	59	1082%	97	181%
2.1 Актив	3	-4	18	-6	-246%	22	595%
2.1.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	3	-4	18	-6	-254%	22	569%
2.1.2 Өрийн бичиг	0	0	0	0	#DIV/0!	0	
2.2 Пассив	8	-57	-132	-65	-817%	-75	-131%
2.2.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	0	-7	-8	-7	-2514%	-1	-14%
2.2.2 Өрийн бичиг	8	-50	-124	-58	-753%	-74	-148%
3. Санхүүгийн үемэл хэрэгслүүд	0	17	0	17	17x	-17	-103%
3.1 Актив	5	0	6	-5	-96%	6	2703%
3.2 Пассив	5	-17	6	-22	-431%	23	138%
4. Бусад хөрөнгө оруулалт	-65	-53	66	12	18%	119	224%
4.1 Актив	394	-155	128	-549	-139%	283	183%
4.1.1 Бусад хөрөнгө	0	0	0	0		0	
4.1.2 Бэлэн мөнгө ба харилцах	323	-152	212	-475	-147%	364	240%
4.1.3 Зээл	12	-2	-5	-14	-121%	-2	-89%
4.1.4 Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем	0	0	0	0		0	
4.1.5 Худалдааны зээл ба урьдчилгаа	59	-1	-79	-60	-101%	-79	79x
4.1.5.1 Богино хугацаат	59	-1	-79	-60	-101%	-79	79x
4.1.5.2 Урт хугацаат	0	0	0	0		0	
4.1.5 Бусад авлага	0	0	0	0		0	
4.2 Пассив	459	-102	63	-561	-122%	165	161%
4.2.1 Бусад хөрөнгө	0	0	0	0		0	
4.2.2 Бэлэн мөнгө ба харилцах	201	17	18	-184	-92%	1	9%
4.2.3 Зээл	280	-106	67	-386	-138%	174	163%
4.2.3.1 Төв банк	0	0	0	0		0	
4.2.3.3 Хадгаламжийн байгууллагууд	-17	-44	81	-28	-168%	125	282%
4.2.3.3.1 Богино хугацаат	26	19	65	-7	-26%	46	244%
4.2.3.3.2 Урт хугацаат	-42	-63	16	-21	-50%	79	125%
4.2.3.2 Засгийн газар	295	58	28	-237	-80%	-30	-52%
4.2.3.4 Бусад салбар	1	-120	-41	-121	-15535%	79	66%
4.2.3.4.1 Богино хугацаат	-9	54	-29	63	728%	-83	-153%
4.2.3.4.2 Урт хугацаат	9	-174	-12	-183	-1955%	162	93%
4.2.4 Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем	0	0	0	0		0	
4.2.5 Худалдааны зээл ба урьдчилгаа	-21	-12	-23	9	42%	-11	-86%
4.2.5.1 Богино хугацаат	11	-12	-23	-23	-216%	-11	-86%
4.2.5.2 Урт хугацаат	-32	0	0	32		0	
4.2.6 Бусад авлага	0	0	0	0	#DIV/0!	0	
4.2.7 Зээлжих тусгай эрх	0	0	0	0		0	
IV. Алдаа болон орхигдуулга	-171	-154	67	16	0	221	1
V. НӨӨХ ХӨРӨНГӨ	-38	-164	-42	-126	-334%	121	74%
1. ГВУН	-38	-164	-12	-126	-334%	152	93%
2. ОУВС-гийн зээл	0	0	31	0		31	
3. Тусгай санхүүжилт	0	0	0	0		0	

ХАВСРАЛТ 2. ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ПОЗИЦИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН (сая ам.доллар)

Үзүүлэлт	12/31/2015	12/31/2016	3/31/2017	6/30/2017	9/30/2017	12/31/2017	3/31/2018
Гадаад хөрөнгө оруулалтын позиц (цэвэр)	-24,701	-29,353	-30,265	-30,994	-31,333	-32,033	-32,592
I. Гадаад актив	3,230	4,309	3,819	3,889	4,466	5,553	5,684
1. Шууд хөрөнгө оруулалт (гадаад руу)	382	455	459	462	478	495	501
1.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө ба ашгийн дахин хөрөнгө оруулалт	369	380	383	386	409	427	437
1.1.1 Салбар компаниас авах	369	380	383	386	409	427	437
1.1.2 Салбар компанид өгөх (-)	0	0	0	0	0	0	0
1.2 Бусад хөрөнгө	13	75	0	0	0	0	0
1.2.1 Салбар компаниас авах	13	75	0	0	0	0	0
1.2.2 Салбар компанид өгөх (-)	0	1	0	0	0	0	0
2. Багцын хөрөнгө оруулалт	235	280	0	0	0	0	0
2.1 Хөрөнгийн хувьцаа	202	259	0	0	0	0	0
2.1.1 Төв банк	0	0	0	0	0	0	0
2.1.2 Засгийн газар	0	3	76	76	69	68	64
2.1.3 Банкууд	3	0	75	75	68	68	63
2.1.4 Бусад салбар	199	256	1	1	1	1	1
2.2 Өрийн бичиг	33	21	0	0	0	0	0
2.2.1 Бонд, үнэт цаас	15	0	0	0	0	0	0
2.2.1.1 Төвбанк	0	0	0	0	0	0	0
2.2.1.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0
2.2.1.3 Банкууд	1	0	0	0	0	0	0
2.2.1.4 Бусад салбар	15	0	0	0	0	0	0
2.2.2 Мөнгөний захын хэрэгсэл	18	0	0	0	0	0	0
2.2.2.1 Төв банк	0	0	0	0	0	0	0
2.2.2.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0
2.2.2.3 Банкууд	0	0	0	0	0	0	0
2.2.2.4 Бусад салбар	18	0	0	0	0	0	0
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	8	280	279	266	257	268	274
3.1 Төв банк	0	259	269	255	244	254	260
3.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0
3.3 Банкууд	8	0	0	0	0	0	0
3.4 Бусад салбар	0	3	45	42	17	18	28
4. Бусад хөрөнгө оруулалт	1,283	0	0	0	0	0	0
4.1 Худалдааны зээллэг	607	256	223	213	226	236	232
4.1.1 Засгийн газар	0	165	165	165	165	168	176
Урт хугацааны	0	91	5	5	4	5	3
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0
4.1.2 Бусад салбар	607	0	0	0	0	0	0
Урт хугацааны	4	0	0	0	0	0	0
Богино хугацааны	603	0	0	0	0	0	0
4.2 Зээл	52	0	0	0	0	0	0
4.2.1 Төв банк	0	21	11	11	13	14	14
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0
4.2.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0
4.2.3 Банкууд	51	0	0	0	0	0	0
Урт хугацааны	47	17	6	6	6	6	6
Богино хугацааны	4	0	0	0	0	0	0
4.2.4 Бусад салбар	1	17	6	6	6	6	6
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	1	0	0	0	0	0	0
4.3 Бэлэн мөнгө ба харилцах	623	0	0	0	0	0	0
4.3.1 Төв банк	0	4	5	5	7	8	8
4.3.2 Засгийн газар	0	0	0	1	1	1	1
4.3.3 Банкууд	441	4	4	4	6	7	7
4.3.4 Бусад салбар	182	0	0	0	0	0	0
4.4 Бусад актив	0	0	0	1	1	1	1
4.4.1 Төв банк	0	4	4	4	6	7	7
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0
4.4.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	100	1	1	1	0	6
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0
4.4.3 Банкууд	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	100	1	1	1	0	6
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0
4.4.4 Бусад салбар	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0
5. Нөөц актив	1,323	1,296	1,109	1,319	1,627	3,008	2,983

Эх сурвалж: Монголбанк

Үргэлжлэл.

Үзүүлэлт	12/31/2015	3/31/2016	6/30/2016	9/30/2016	12/31/2016	3/31/2017	6/30/2017	9/30/2017	12/31/2017	3/31/2018
Гадаад пассив	32,539	33,272	33,717	33,952	33,662	34,083	34,883	35,800	37,586	38,276
Шууд хөрөнгө оруулалт	20,696	20,903	16,409	16,308	16,277	16,540	16,854	17,378	18,020	18,520
Хувьцаа ба хөрөнгө оруулалтын	9,575	9,570	9,213	9,052	8,851	8,999	9,245	9,514	10,023	10,286
Шууд хөрөнгө оруулалттай	9,575	9,570	9,213	9,052	8,851	8,999	9,245	9,514	10,023	10,286
Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө	0	0	0	0	0	0	0	0	0	0
Хамааралтай компани хоорондын	0	0	0	0	0	0	0	0	0	0
үүнээс: Хөрөнгө оруулалтын сангийн	0	0	0	0	0	0	0	0	0	0
үүнээс: Мөнгөний захын сангийн	0	0	0	0	0	0	0	0	0	0
Өрийн хэрэгсэл	11,121	11,333	7,196	7,256	7,426	7,541	7,609	7,864	7,996	8,234
Шууд хөрөнгө оруулалттай компанид	11,121	11,333	7,196	7,256	7,426	7,541	7,609	7,864	7,996	8,234
Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай	0	0	0	0	0	0	0	0	0	0
Хамааралтай компани хоорондын	0	0	0	0	0	0	0	0	0	0
Багцын хөрөнгө оруулалт	3,067	3,048	3,692	3,717	3,631	3,863	4,343	4,483	4,937	4,759
Хувьцаа ба хөрөнгө оруулалтын	80	73	78	70	71	67	67	70	71	71
Төв банк	0	0	0	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч	0	0	0	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллага (Төв)	11	11	11	11	11	11	11	11	11	11
Засгийн газар (Төрийн удирдлагын)	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	69	62	67	59	60	56	56	59	60	60
Бусад санхүүгийн байгууллага	0	0	0	0	0	0	0	0	0	0
Санхүүгийн бус байгууллага,	0	0	0	0	0	0	0	0	0	0
Хөрөнгө оруулалтын сангийн нэгж	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бүртгэлтэй	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бүртгэлгүй	0	0	0	0	0	0	0	0	0	0
Хөрөнгө оруулалтын сангийн	0	0	0	0	0	0	0	0	0	0
үүнээс: Мөнгөний захын	0	0	0	0	0	0	0	0	0	0
Өрийн бичиг	2,987	2,975	3,614	3,647	3,560	3,796	4,275	4,413	4,866	4,687
Төв банк	0	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацаат	0	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацаат	0	0	0	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч	0	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацаат	0	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацаат	0	0	0	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллага (Төв)	652	660	650	620	611	575	562	602	589	608
Богино хугацаат	0	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацаат	652	660	650	620	611	575	562	602	589	608
Засгийн газар (Төрийн)	1,473	1,451	2,064	2,140	2,064	2,916	2,986	3,085	3,549	3,340
Богино хугацаат	0	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацаат	1,473	1,451	2,064	2,140	2,064	2,916	2,986	3,085	3,549	3,340
Бусад салбарууд	862	865	899	887	886	304	727	727	728	738
Богино хугацаат	2	2	2	2	2	2	2	2	2	2
Урт хугацаат	860	863	897	885	884	302	725	724	726	736
Бусад санхүүгийн байгууллага	0	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацаат	0	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацаат	0	0	0	0	0	0	0	0	0	0
Санхүүгийн бус байгууллага,	0	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацаат	0	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацаат	0	0	0	0	0	0	0	0	0	0
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс)	166	170	167	180	116	0	1	(0)	(0)	6
Төв банк	0	0	0	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч	0	0	0	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв)	166	170	167	180	116	0	1	(0)	(0)	6
Засгийн газар (Төрийн)	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	0	0	0	0	0	0	0	0	0	0
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бусад хөрөнгө оруулалт	8,610	9,151	13,450	13,746	13,638	13,680	13,686	13,939	14,630	14,992
Бусад хөрөнгө	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бэлэн мөнгө ба харилцах	1,954	2,158	1,848	1,934	1,965	2,003	2,092	2,225	2,245	2,365
Төв банк	1,772	1,928	1,654	1,649	1,725	1,741	1,770	1,805	1,837	1,913
Богино хугацаат	1,772	1,928	1,654	1,649	1,725	1,741	1,770	1,805	1,837	1,913
Урт хугацаат	0	0	0	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч	0	0	0	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв)	182	230	193	285	240	253	308	318	314	330
Богино хугацаат	0	0	0	0	0	253	308	318	314	330
Урт хугацаат	182	230	193	285	240	0	0	0	0	0
үүнээс: Банк хоорондын	0	0	0	0	0	0	0	0	0	0
Засгийн газар (Төрийн)	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	0	0	0	0	0	9	14	103	95	122
Зээл	6,398	6,735	11,288	11,555	11,457	11,471	11,395	11,428	12,105	12,354
Төв банк	68	68	68	68	65	66	106	109	188	224
ОУВС-гаас авсан зээл (нөөцөөс)	68	68	68	68	65	66	106	109	188	224
Бусад богино хугацаат	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бусад урт хугацаат	0	0	0	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч	0	0	0	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв)	1,294	1,292	1,372	1,636	1,567	1,522	1,308	1,311	1,291	1,408
Богино хугацаат	407	444	465	491	469	488	414	403	345	439
Урт хугацаат	887	848	907	1,145	1,098	1,034	894	908	946	970
Засгийн газар (Төрийн)	2,287	2,622	2,722	2,759	2,805	2,928	3,031	3,156	3,772	3,902
ОУВС-гаас авсан зээл (нөөцөөс)	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бусад богино хугацаат	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бусад урт хугацаат	2,287	2,622	2,722	2,759	2,805	2,928	3,031	3,156	3,772	3,902
Бусад салбарууд	2,749	2,752	7,126	7,092	7,020	6,955	6,950	6,852	6,853	6,820
Богино хугацаат	260	252	296	276	218	274	328	310	292	266
Урт хугацаат	2,489	2,500	6,830	6,815	6,802	6,681	6,622	6,542	6,560	6,554
Бусад санхүүгийн байгууллага	0	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацаат	0	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацаат	0	0	0	0	0	0	0	0	0	0
Санхүүгийн бус байгууллага,	2,749	2,752	7,126	7,092	7,020	6,955	6,950	6,852	6,853	170
Богино хугацаат	260	252	296	276	218	274	328	310	292	83
Урт хугацаат	2,489	2,500	6,830	6,815	6,802	6,681	6,622	6,542	6,560	87
Даатгал, тэтгэвэр болон стандарт	0	0	0	0	0	0	0	0	0	0
Худалдааны зээл ба урьдчилгаа	138	170	279	245	216	206	199	286	280	274
Бусад дансны авлага/өглөг	120	88	36	12	0	0	0	0	0	0

ХАВСРАЛТ 3. МОНГОЛ УЛСЫН НИЙТ ГАДААД ӨР (сая ам.доллар)

Үзүүлэлт	12/31/2015	3/31/2016	6/30/2016	9/30/2016	12/30/2016	3/31/2017	6/30/2017	9/30/2017	12/31/2017	3/31/2018
Засгийн газар	3,759.9	4,072.7	4,785.8	4,899.6	4,868.6	5,844.1	6,016.2	6,241.0	7,321.0	7,242.5
Төвбанк	1,959.6	2,084.5	1,758.0	1,729.2	1,790.8	1,807.4	1,876.7	1,914.1	2,025.1	2,136.6
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	2,128.5	2,181.6	2,215.6	2,539.9	2,417.4	2,350.7	2,177.3	2,230.6	2,194.3	2,346.5
Бусад салбарууд	3,748.9	3,786.9	8,304.1	8,224.2	8,121.5	7,473.5	7,890.6	7,966.8	7,955.8	7,953.5
Шууд хөрөнгө оруулалт: Компани хоорондын зээллэг	11,120.9	11,333.4	7,196.0	7,256.1	7,426.3	7,541.0	7,608.5	7,863.9	7,996.5	8,233.6
Нийт гадаад өр	22,717.8	23,459.0	24,259.6	24,649.1	24,624.5	25,016.6	25,569.4	26,216.3	27,492.7	27,912.6